



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/Н08

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 14/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын сонгуулийн нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулах нэгдсэн самбар хийхэд шаарлагатай нэмэлт зардлын санхүүжилтэд 54,700,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 54,700,000 (тавин дөрвөн сая долоон зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2024 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 07-ны өдрийн
А/408 дугаар захирамжийн хавсралт



СУМДЫН ОЛГОХ САНХҮҮЖИЛТИЙН ЖАГСААЛТ

Д/д	Нэрс	Мөнгөн дүн
1	Алтай	2,500,000
2	Булган	2,500,000
3	Буянт	2,500,000
4	Дарви	2,500,000
5	Дөргөн	2,500,000
6	Дуут	2,500,000
7	Зэрэг	2,500,000
8	Манхан	2,500,000
9	Мөст	2,500,000
10	Мөнххайрхан	1,500,000
11	Мянгад	2,000,000
12	Үенч	2,500,000
13	Ховд	2,500,000
14	Цэцэг	2,000,000
15	Чандмань	2,500,000
16	Эрдэнэбүрэн	2,500,000
17	Жаргалант	16,700,000
	Нийт	54,700,000

-оОо-